

Дотоод хэргийн их сургуулийн 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 03 дугаар албан бичгийн хэвсрэлт /594

2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү удирдамжаар магистр, докторын сургалтын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргаж бүртгүүлсэн албан хаагч, иргэдээс авах шалгалтын төрөл, хэлбэр, элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, Элсэгчдийн шалгалтын дүнг эрэмбэлэх аргачлал зэргийг тогтооход оршино.

1.2.Элсэлтийн шалгалтыг зохион байгуулахад Дотоод хэргийн их сургуулийн Магистр, докторын элсэлтийн журам болон энэ удирдамжийг баримтална.

1.3.Элсэлтийн шалгалтын үйл ажиллагааг Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Хилчний гудамж (бүсчлэлийн код 13260)-д байрлах Их сургуулийн байранд (цаашид Их сургуулийн байрлал гэх) зохион байгуулна.

1.4.Элсэлтийн шалгалттай холбогдох мэдээллийг Их сургуулийн "[www.uia.gov.mn](http://www.uia.gov.mn)" цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

**Хоёр.Элсэлтийн бүртгэл**

2.1. Магистр, докторын хөтөлбөрт элсэгчдэд тавих нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан иргэд 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04 дугаар сарын 15-ний өдрүүдэд "[www.uia.gov.mn](http://www.uia.gov.mn)" сайтаар бүртгүүлнэ.

**Гурав. Элсэлт зохион байгуулах хуваарь**

д/д	Элсэлт зохион байгуулах чиглэл	Он, сар, өдөр, цаг	Хариуцах газар, албан тушаалтан
Магистр, докторын элсэлтийн бүртгэл			
1	Магистр, докторын элсэлтийн бүртгэл	2024.03.20-04.15-ний хүртэлх өдрүүдэд	Цахимаар бүртгүүлнэ <a href="http://www.uia.gov.mn">www.uia.gov.mn</a>
Докторын хөтөлбөрийн элсэлтийн шалгалт			
2	Мэргэжлийн мэдлэг	2024.04.16-ны 10.00 цаг	Комиссын бүрэлдэхүүн
3	Гадаад хэл	2024.04.16-ны 14.00 цаг	Комиссын бүрэлдэхүүн
4	Ярилцлага	2024.04.17-нд 10.00-16.00 цаг	Комиссын бүрэлдэхүүн
Магистрын хөтөлбөрийн элсэлтийн шалгалт			
5	Мэргэжлийн мэдлэг	2024.04.17-ний 10.00 цаг	Комиссын бүрэлдэхүүн
6	Гадаад хэл	2024.04.17-ны 14.00 цаг	Комиссын бүрэлдэхүүн
7	Ярилцлага	2024.04.18-нд 10.00-16.00 цаг	Комиссын бүрэлдэхүүн
Элсэлтийн шалгалтын дараах үйл ажиллагаа			
8	Шалгалтын дүн нэгтгэх	2024.04.19-04.22	
9	Тэнцсэн алба хаагчдын нэрийг агентлагуудад хүргүүлэх	2024.04.22	Комиссын бүрэлдэхүүн
10	Захиалагч байгууллагаас суралцуулах элсэгчийн нэрсийг хүлээн авах	2024.04.25	Нарийн бичгийн дарга

11	Сургалтын төлбөр төлсөн баримтыг үндэслэн элсүүлэх тухай их сургуулийн захирлын тушаал гаргах	2024.04.22-04.29	Нарийн бичгийн дарга
12	Элсүүлэн суралцуулах тухай тушаалыг захиалагч байгууллагад хүргүүлэх	2024.04.30	Нарийн бичгийн дарга
13	Их сургуулийн захиралд элсэлт зохион байгуулсан тухай илтгэх хуудсаар танилцуулах	2024.04.30	Нарийн бичгийн дарга

### Дөрөв. Шалгалтын төрөл, хэлбэр, агуулга

4.1.Магистрын хөтөлбөрт Элсэгчээс дараах шалгалтыг авна.

д/д	Шалгалтын төрөл	Хөтөлбөрийн нэр	Хэлбэр	Агуулга
1	Гадаад хэл /30 оноо/	Гэмт явдал судлал; Хил судлал; Онцгой байдал-гамшиг судлал; Шинжлэн магадлахуй; Хууль сахиулах удирдлага; Цагдаа судлал; Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Кибер гэмт хэрэг судлал; Эдийн засгийн аюулгүй байдал; Эрх зүй.	20 сорил, орчуулах текст	Анхан дундаас дээш түвшний агуулгатай байна. /Орос, Англи хэлний аль нэг нь байж болно/
2	Ярилцлага /20 оноо/	Гэмт явдал судлал; Хил судлал; Онцгой байдал-гамшиг судлал; Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Шинжлэн магадлахуй; Хууль сахиулах удирдлага; Цагдаа судлал; Кибер гэмт хэрэг судлал; Эдийн засгийн аюулгүй байдал; Эрх зүй.	Ярилцлаг а	Урьдчилан ирүүлсэн судалгааны ажлын талаарх танилцуулгын хүрээнд ярилцана.
3	Мэргэжлийн мэдлэг /50 оноо/	Гэмт явдал судлал	50 сорил	Үндсэн хуулийн эрх зүй-10, Эрүүгийн эрх зүй-10, Криминологи-10 Эрүүгийн процессын эрх зүй-20,
		Хил судлал	50 сорил	Хилийн алба-15 Шалган нэвтрүүлэх алба-10 Ар тал-10 Хилийн эрх зүй-15
		Онцгой байдал-гамшиг судлал	50 сорил	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа-20 Гал түймэртэй тэмцэх асуудал-20 Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр-10

	Шинжлэн магадлахуй	50 сорил	Шинжлэн магадлахуйн эрх зүй-10 Эрүүгийн процессын эрх зүй-5 Байгалийн ухаан-5 Хэргийн газрын үзлэг-10 Шинжилгээний арга зүй-20
	Хууль сахиулах удирдлага	50 сорил	Менежмент-20 Аюулгүй байдал-10 Эрх зүй-20
	Цагдаа судлал	50 сорил	Үндсэн хуулийн эрх зүй-10 Эрүүгийн эрх зүй-10 Цагдаагийн эрх зүй-30
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	50 сорил	Баривчлах, цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа - 25 Хорих ял эдлүүлэх ажиллагаа - 25
	Эдийн засгийн аюулгүй байдал	50 сорил	Эдийн засаг-20 Аюулгүй байдал-10 Эрх зүй-20
	Кибер гэмт хэрэг судлал	50 сорил	Техникийн ухаан-20 Аюулгүй байдал-10 Эрх зүй-20
	Эрх зүй	50 сорил	Үндсэн хуулийн эрх зүй-10 Хувийн эрх зүй-20 Нийтийн эрх зүй-20

#### 4.2. Докторын хөтөлбөрт Элсэгчээс дараах шалгалтыг авна.

д/д	Шалгалтын төрөл	Хөтөлбөрийн нэр	Хэлбэр	Агуулга
1	Гадаад хэл /30 оноо/	Гэмт явдал судлал; Хил судлал; Шинжлэн магадлахуй; Онцгой байдал-гамшиг судлал; Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Хууль сахиулах удирдлага; Эрх зүй.	20 сорил Орчуулах текст	Дунд түвшний агуулгатай байна. /Орос, Англи хэлний аль нэг нь байж болно/
2	Ярилцлага /20 оноо/	Гэмт явдал судлал; Хил судлал; Шинжлэн магадлахуй; Шүүхийн шийдвэр гүйцэтгэл Онцгой байдал-гамшиг судлал; Хууль сахиулах удирдлага; Эрх зүй.	Ярилцлага	Урьдчилан ирүүлсэн судалгааны ажлын талаарх танилцуулгын хүрээнд ярилцана.

3	Мэргэжлийн мэдлэг /50 оноо/	Гэмт явдал судлал	50 сорил	Үндсэн хуулийн эрх зүй-10, Эрүүгийн эрх зүй-10, Криминологи-10 Эрүүгийн процессын эрх зүй-20,
		Хил судлал	50 сорил	Хилийн алба-15 Шалган нэвтрүүлэх алба-10 Ар тал-10 Хилийн эрх зүй-15
		Онцгой байдал-гамшиг судлал	50 сорил	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа-20 Гал түймэртэй тэмцэх асуудал-20 Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр-10
		Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	50 сорил	Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа - 10 Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа - 15 Хорих ял эдлүүлэх ажиллагаа - 25
		Шинжлэн магадлахуй	50 сорил	Шинжлэн магадлахуйн эрх зүй-10 Эрүүгийн процессын эрх зүй-5 Байгалийн ухаан-5 Хэргийн газрын үзлэг-10 Шинжилгээний арга зүй-20
		Хууль сахиулах удирдлага	50 сорил	Менежмент-20 Аюулгүй байдал-10 Эрх зүй-20
		Эрх зүй	50 сорил	Үндсэн хуулийн эрх зүй-10 Хувийн эрх зүй-20 Нийтийн эрх зүй-20

4.3.Гадаад хэлний институт англи, орос хэлний анхан дунд, дунд түвшний тус бүр 50-аас доошгүй сорилыг, хөтөлбөр хариуцсан бүрэлдэхүүн сургууль мэргэжлийн мэдлэгийн зохих түвшний шаардлагад нийцсэн тус бүр 70-аас доошгүй сорилыг боловсруулж, нууцлалыг ханган элсэлтийн шалгалтын комиссын нарийн бичгийн даргад 2024 оны 04 дугаар сарын 01-ны өдөрт багтаан ирүүлнэ.

4.4.Элсэлтийн шалгалтын комиссын нарийн бичгийн дарга ирүүлсэн сорилд боловсруулалт хийж, шалгалтын комиссын даргаар батлуулж, шалгалт өгөх элсэгчийн тоогоор хувилж битүүмжилнэ.

4.5.Элсэгч Шалган нэвтрүүлэх байраар бүртгэлийн хуудас, албаны үнэмлэх (албан хаагч биш бол иргэний үнэмлэх)-ийн хамт үзүүлж нэвтэрнэ.

4.6.Элсэгч элсэлтийн шалгалтын хуваарийн товлосон цагаас 30 минутын өмнө сургуулийн байрлалд ирж, байраа эзэлнэ.

#### Тав.Элсүүлэх шийдвэр гаргах

5.1.Элсэгчийн мэргэжлийн болон гадаад хэл, ярилцлагын шалгалтын онооны нийлбэр дүнгээр эрэмбэлж жагсаана.

5.2. Комиссын хуралдаанаар элсэлтийн шалгалтын дүнг хэлэлцэн, шалгуур хангаж, шалгалтад тэнцсэн элсэгчийн нэрсийн жагсаалтыг нэгтгэн гаргана.

5.3. Өдрийн докторын хөтөлбөрт тэнцсэн албан хаагч тухайн байгууллагаас тодорхойлолт авч, суралцах боломжтой талаар шийдвэр гаргасан байна.

5.4. Тухайн хөтөлбөрт элсэгчдийн анги дүүргэлт 3-аас багагүй байна. Бага тохиолдолд дараагийн хичээлийн жил хүртэлх хугацаагаар сургалт хойшлуулна.

5.5. Магистр, докторын элсэлт зохион байгуулах журам (Ж.202-03)-ын 7 дугаар зүйлийн 7.2.10-т зааснаар докторын сургалтын хөтөлбөрийн 36 багц цаг, магистрын сургалтын хөтөлбөрийн 27 багц цагийн төлбөрийн 50-аас доошгүй хувийг заасан хугацаанд төлсөн тохиолдолд "Элсүүлэн суралцуулах тухай" тушаалыг Их сургуулийн захирал гаргана.

5.6. Их сургуулийн захирлын "Элсүүлэн суралцуулах тухай" тушаал, сургалтын төлөвлөгөөний дагуу дуудах хуудсыг харьяалах байгууллагад нь илгээнэ.

5.7. Магистр, докторын хөтөлбөрт элсэлт зохион байгуулсан тухай илтгэх хуудсыг Их сургуулийн захиралд 2024 оны 04 дугаар сарын 30-ны өдөр танилцуулна.

### **Зургаа. Өргөдөл гомдол шийдвэрлэх**

6.1. Элсэлтийн үйл явц, комиссын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг 2024 оны 03 дугаар сарын 20-оос 04 дүгээр сарын 28-ны хооронд бичгээр болон цахимаар авна.

6.2. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгээр зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ. Хариуг амаар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.

6.3. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг Их сургуулийн захирал 5 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ